



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 02 өдөр

Дугаар А/690

Булган сум

Эрх шилжүүлж, ажил гүйцэтгүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.3, 66 дугаар зүйлийн 66.1, Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, Засгийн газрын 2015 оны 430, 2016 оны 179 дүгээр тогтоол, Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралдааны 2020 оны II/03 дугаар тогтоолоор баталсан Засаг даргын “Шинэ хөгжлийн зам” үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.3.1.1 дэхь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Булган аймаг, “Эрдэнэт Үйлдвэр” Төрийн Өмчит Үйлдвэрийн газрын 2023 оны хамтран ажиллах гэрээнд тусгагдсан төсөл арга хэмжээнээс хавсралтад заагдсан төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулах эрхийг Хутаг-Өндөр сумын Засаг дарга (П.Лхагва-Очир)-д шилжүүлсүгэй.

2.Эрх шилжүүлсэн төсөл арга хэмжээний гүйцэтгэгчид холбогдох хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж ажиллахыг Хутаг-Өндөр сумын Засаг дарга (П.Лхагва-Очир)-д үүрэг болгосугай.

3.Ажлын гүйцэтгэлээр санхүүжилтийг олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

Аймгийн Засаг даргын 20²³ оны
10 дүгээр сарын 02-ны өдрийн А/600 дугаар
захирамжийн хавсралт

БУЛГАН АЙМАГ, "ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР" ТӨҮГ-ЫН
2023 ОНЫ ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУСГАГДСАН ЗААЛТ

д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хариуцах байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Санхүүжилт /Сая, төг/	Хүрэх үр дүн
1	2	3	4	5	6	7
<i>Нэг. Байгаль орчин, экологийн чиглэлээр:</i>						
1	Аялал жуулчлалын үйлчилгээ явуулдаг аж ахуйн нэгж байгууллагын хог хаягдлын менежментийг сайжруулах, Био нойлтой болгоход дэмжлэг үзүүлэх /Хутаг-өндөр сум/	Жилдээ	Сумын ЗДТГ, БОАЖГ	Булган АЗДТГ	20.0	Аялал жуулчлын бүс нутагт тав тухтай амрах орчин бүрдэж, аялагч жуулчдын тоо нэмэгдэнэ. Булган аймагт жилдээ 100,000 гаруй жуулчид ирдэг.